

ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАХ АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн төсвийн байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй аудитын хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээд нь төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланг УСНББОУС болон тэдгээрт нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэл, тайлагналын холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг Төсвийн хуульд заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэнэ.

Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь дараах материалыг ирүүлнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
- Татварын байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт
- ШШГЕГ-ын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт
- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт
- ММНБИ-ийн тодорхойлолт
- Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/
- Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар
- Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/
- Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 70422930 тоот утсаар авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2024 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 17 цагаас өмнө bayanulgii@audit.gov.mn хаягаар, цаасаар ирүүлнэ үү.

Хаяг: Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 1 дүгээр давхар, 103, 104 тоот өрөө

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

